



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2022 оны 12 сарын 15 өдөр

Дугаар А/608

Улаанбаатар хот

Геронтологийн үндэсний төвийн дүрэм,  
бүтэц батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дүгээр заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.4 дэх заалт, 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь

1. Геронтологийн үндэсний төвийн дүрмийг нэгдүгээр, бүтцийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Батлагдсан дүрэм, бүтцийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллахыг Геронтологийн үндэсний төв /Р.Хишигжаргал/-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга /Ц.Эрдэмбилэг/-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2013 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн 226 дугаар тушаалыг хүчингүйд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141222923



## ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДҮРЭМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Геронтологийн үндэсний төв нь Насжилт судлал (Геронтологи), Настны эмгэг судлалын (Гериатр) чиглэлээр улсын хэмжээнд лавлагаа шатлалын мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх, эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг зохион байгуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий тусгай мэргэжлийн лавлагаа төв (цаашид төв гэх) байна.
- 1.2 Төв нь Монгол Улсын Үндсэн хууль, Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хууль, Эрүүл мэндийн даатгалын тухай хууль, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хууль, Ахмад настны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд үйл ажиллагаа явуулна.
- 1.3 Төв нь үндэсний болон салбарын хөгжлийн бодлого, стратеги төлөвлөгөөтэй уялдсан байгууллагын стратеги төлөвлөгөөг 4 жилийн хугацаатайгаар Эрүүл мэндийн сайдаар батлуулж хэрэгжүүлнэ.
- 1.4 Төв нь “Геронтологийн үндэсний төв” гэсэн хаягтай, төвийн нэрийг англиар “National Center for Gerontology” гэж орчуулна.
- 1.5 Төв нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас, билэгдэл, туг, санхүүгийн харилцах данстай байна.
- 1.6 Төв нь албан ёсны цахим хуудастай байж, тогтмол шинэчлэн баяжуулж ажиллана.

### Хоёр. Төвийн үйл ажиллагааны зарчим

Төв нь үйл ажиллагаандаа дараах зарчмыг баримтлана.

- 2.1 Төрийн хуулийг чандлан сахиж шударга, ил тод байх (хууль тогтоомжийг дээдлэн үйл ажиллагаандаа шударга ёс, ил тод байдлыг хангана);
- 2.2 Мэргэжлийн ур чадвартай байх (хариуцсан ажил үүргээ гүйцэтгэх мэргэжлийн өндөр түвшний мэдлэг, ур чадварыг эзэмшиж, түүнийгээ байнга хөгжүүлнэ);
- 2.3 Мэргэшсэн, тогтвортой хүний нөөцтэй байх (хүний нөөцийн мэргэшсэн, тогтвортой байдлыг хангаж, эмч эмнэлгийн мэргэжилтэн ажилтныг албан тушаалын шаардлагад нийцүүлэн томилно);
- 2.4 Ёс зүй, харилцаа хандлага, хариуцлагатай байх (төрийн албан хаагчийн болон эмнэлгийн мэргэжилтний ёс зүйг эрхэмлэнэ);
- 2.5 Тусламж, үйлчилгээнд олон улсад болон үндэсний хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, удирдамжийг ашиглаж үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг бүрэн хангана;



2.6 Хүнлэг, энэрэнгүй байх (үйлчлүүлэгчийг дээдлэн хүнлэг, энэрэнгүй хандаж тохирсон оношилгоо, эмчилгээ, бусад тусламж, үйлчилгээг үзүүлнэ).

2.7 Бүтээлч, санаачлагатай байх (аливаа асуудалд шинжлэх ухаанч байдлаар хандаж, шинэ техник, технологи, инновацийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэн, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтан бүр хариуцсан ажилдаа бүтээлч санаачлагатай байна);

2.8 Суралцагч хамт олон байх (дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, олон улсын туршлага, нотолгоонд суурилсан орчин үеийн оношилгоо, эмчилгээний аргуудаас байнга суралцаж, эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилтан бүр харилцан сургагч, суралцагч хамт олон байж, эдгээрийн сурч хөгжих, ахиж дэвших орчныг бүрдүүлнэ);

2.9 Иргэд олон нийтэд түшиглэх (төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжтэй түншлэл, хамтын ажиллагааг өргөжүүлж, өөрийн үйл ажиллагаагаар тэдний итгэл, хүндэтгэлийг хүлээж, харилцан хамтарч ажиллана);

2.10 Хяналт, үр дүнг чухалчлах (дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн ажлын гүйцэтгэл, үр дүн, үр нөлөөг байнга үнэлэн дүгнэж, сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах);

### **Гурав. Төвийн алсын хараа, эрхэм зорилго, үнэт зүйл**

3.1 Төвийн алсын хараа: Эрүүл, идэвхтэй насжилт хүн бүрийн ирээдүй

3.2 Төвийн эрхэм зорилго:

Монгол хүний насжилт, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судалж, өвчлөлөөс сэргийлэх, оношлох, эрүүлжүүлэх, сэргээн засах, нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, үйлчлүүлэгчдийг дээдэлсэн тогтолцоог бүрдүүлэн хамт олны хөгжил дэвшлийг хангах

3.3 Төвийн үнэт зүйл;

3.3.1 Ахмад настны бие даасан байдлыг үнэлэх

3.3.2 Хүнлэг энэрэнгүй байх

3.3.3 Тэгш хүртээмжтэй байх

3.3.4 Үйлчүүлэгч төвтэй байх

3.3.5 Ахмад настны оролцоог хангах

3.3.6 Байгууллагын соёл

3.3.7 Үйлчлүүлэгч болон ажилчдын сэтгэл ханамж, итгэл

3.3.8 Мэргэшсэн ёс зүйтэй, ур чадвартай хүний нөөц

### **Дөрөв. Төвийн үндсэн чиглэл, эрх, үүрэг**

4.1 Төвийн үндсэн чиглэл;

4.1.1 Геронтологийн үндэсний төв нь тусгай мэргэшлийн нотолгоонд суурилсан, чанар, аюулгүй байдлыг хангасан эмнэлгийн тусламж үйлчилгээ үзүүлэх;

4.1.2 Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад тусгай мэргэшлээрээ мэргэжил, арга зүйн лавлагаа тусламж үзүүлэх;

4.1.3 Анагаах ухааны дэвшилтэт технологи, ололт амжилт, арга технологи, инновацийг эмчилгээ, үйлчилгээнд нэвтрүүлэн үр дүнг тооцож санал



боловсруулан ажиллах;

4.1.4 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт, сургалт-эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх;

4.2 Төвийн эрх, үүрэг.

4.2.1 Төвийн эрх.

4.2.1.1 Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хууль, тогтоол, Эрүүл мэндийн сайдын тушаал, хөгжлийн хөтөлбөр, төсөл стандарт, заавар зөвлөмжийн хэрэгжилтийг хангах, гүйцэтгэлийг хянах;

4.2.1.2 Өөрийн чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардагдах бүтэц, нөөц, төсвийг бүрдүүлж, хууль тогтоомж, дүрэм, журмын дагуу захиран зарцуулах;

4.2.1.3 Улсын хэмжээнд Насжилт судлал (Геронтологи), настны эмгэг судлалын (Гериатр) чиглэлээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлж мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, нотолгоонд суурилсан мэргэжлийн дүгнэлт гаргах,

4.2.1.4 Настанд зонхилон тохиолдох өвчлөл, нас баралтын байдал, шалтгааныг судлан дүгнэх, түүнийг бууруулах арга хэмжээ авах;

4.2.1.5 Насжилт судлал, настны эмгэг судлалын тусламж, үйлчилгээнд тулгамдсан асуудлаар нотолгоонд суурилсан үндэслэл бүхий санал боловсруулан төрийн захиргааны төв байгууллагад танилцуулах, шийдвэрлүүлэх;

4.2.1.6 Бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллах;

4.2.1.7 Чанартай тусламж, үйлчилгээг стандартын дагуу хүртээмжтэй үзүүлэхэд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хөрөнгө оруулалтын асуудлыг төрийн захиргааны төв байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

4.2.1.8 Өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллагад мэргэжил, арга зүйн лавлагаа тусламж үзүүлж, хамтран ажиллах;

4.2.1.9 Эрдэм шинжилгээ, судалгааны төсөл боловсруулах, хэрэгжүүлэх, үр дүнг тооцох, үндэсний болон олон улсын эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөн, сургалт зохион байгуулах, ном товхимол, зөвлөмж заавар хэвлүүлэх, нийтийн хүртээл болгох;

4.2.1.10 Олон улсын байгууллага, гадаад, дотоодын ижил чиг үүрэг бүхий байгууллагатай хамтын ажиллагааг өргөжүүлэх, хамтарсан төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, судалгаа хийх, туршлага солилцох асуудлаар төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөж харилцан ойлголцлын санамж байгуулах;

4.2.1.11 Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад эрх;

4.2.2 Төвийн үүрэг;

4.2.2.1 Төв нь чиг үүрэг, эрхэм зорилго, стратегийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны дунд хугацааны стратеги төлөвлөгөө, хөгжлийн хөтөлбөр, эрсдэлийн удирдлагын журам боловсруулах, хэрэгжилтийг хангах;



- 4.2.2.2 Улсын хэмжээнд Насжилт судлал (Геронтологи), настны эмгэг судлалын (Гериатр) чиглэлээр тусгай мэргэжлийн тусламж үйлчилгээг мэргэжлийн өндөр түвшинд чанартай, аюулгүй, хүртээмжтэй үзүүлэх;
- 4.2.2.3 Үйлчлүүлэгчийг дээдлэн, үйлчилгээний ээлтэй, тав тухтай орчинг бүрдүүлэх;
- 4.2.2.4 Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалт зохион байгуулах, орон нутгийн эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийн мэргэжлийн ур чадварыг бэхжүүлэх, ажлын байрны болон алсын зайн сургалт зохион байгуулах;
- 4.2.2.5 Санхүү, төсвийн нээлттэй, ил тод зарчмыг баримтлан “Төсвийн тухай хууль”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль”, “Шилэн дансны тухай хууль” болон бусад холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэх;
- 4.2.2.6 Эрүүл мэндийн технологи, оношилгоо, эмчилгээний стандарт, эмнэлзүйн заавар, удирдамжийн хэрэгжилтэд байнгын хяналт тавьж, чанар сайжруулах арга аргачлал, хэрэгслийг нэвтрүүлэн, тогтмолжуулан ажиллах;
- 4.2.2.7 Эмнэлгийн ажилтны ажиллах таатай нөхцлийг бүрдүүлэх, эрүүл, аюулгүй ажлын байраар хангах, мэргэжил ур чадварт тохирсон цалин хөлс олгох, мэргэжил, мэдлэг, ур чадварын түвшинг тасралтгүй дээшлүүлэх;
- 4.2.2.8 Эмнэлгийн ажилтны мэдлэг, мэргэжлийн ур чадвар, сахилга хариуцлагыг сайжруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлэх;
- 4.2.2.9 Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдол, санал, хүсэлтэд дүн шинжилгээ хийж шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх, залруулах арга хэмжээг хэрэгжүүлэх;
- 4.2.2.10 Ажилтнуудын нийгмийн баталгаа, тогтвор сууршилтай ажиллах нөхцөлийг хангах, мэргэжил ур чадварт тохирсон цалин хөлс олгох, мэдлэг ур чадварыг дээшлүүлэх сургалтад тасралтгүй хамруулах;
- 4.2.2.11 Иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, сургалт сурталчилгааны ажлыг тогтмол зохион байгуулах, тусламж үйлчилгээтэй холбоотой мэдээллээр хангах;
- 4.2.2.12 Гамшиг, онцгой байдал, яаралтай тусламжийн бэлэн байдал хангах, болзошгүй гамшгаас урьдчилан сэргийлэх нөөц, эрсдлийн сан бүрдүүлж, удирдаж ажиллах;
- 4.2.2.13 Барилга байгууламж, эмнэлгийн тоног төхөөрөмж, техник, хэрэгслийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн талаарх холбогдох хууль, стандартын шаардлагыг ханган ажиллах;
- 4.2.2.14 Төрийн өмчийн эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эд хөрөнгийн бүртгэл тооллогыг тогтоосон хутагаанд хийх, данснаас хасах, шилжүүлэх, устгал хийх асуудлыг холбогдох газарт тавьж шийдвэрлүүлэх;
- 4.2.2.15 Төвийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, бүтэц, зохион байгуулалт, хүний нөөцийн мэдээлэл, төсөв санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж буй тусламж, үйлчилгээ болон бусад мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангах;
- 4.2.2.16 Эрүүл мэндийн тухай хууль тогтоомж болон бусад холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн бусад үүрэг;



## Тав. Бүтэц, зохион байгуулалт

5.1 Төвийн удирдах дээд албан тушаалтан нь төвийн Захирал байх бөгөөд төвийн үйл ажиллагааг удирдлага, арга зүйгээр хангах, үр дүнг Эрүүл мэндийн сайдын өмнө тайлагнах, хариуцлага хүлээх үүрэг бүхий төрийн албан хаагч мөн.

5.2 Төвийн захирал нь Дэд захирал, Эмнэлгийн тусламж үйлчилгээний албаны дарга, Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба, Стратеги төлөвлөлтийн албаны дарга, Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын албаны дарга, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын албаны дарга, Санхүү бүртгэлийн албаны дарга болон бусад төлөөллийг оролцуулсан Удирдлагын зөвлөлийг байгуулж, ажиллах журмыг тогтооно.

5.3 Төв нь эрдэм шинжилгээний ажлын хэтийн болон ойрын зорилт, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, судалгаа шинжилгээний сэдэв, арга зүй, явц, үр дүнг хэлэлцэх, тэдгээрт үнэлэлт, дүгнэлт гаргах эрдэм судлалын ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах үүрэг бүхий Эрдмийн зөвлөл ажиллуулж, бүрэлдэхүүн, ажиллах журмыг холбогдох хууль тогтоомж, тушаал шийдвэрт нийцүүлэн захирлын тушаалаар батална.

5.4 Төвийн захирал тушаал, Удирдлагын зөвлөл болон Эрдмийн зөвлөл нь хурлын шийдвэр, тэмдэглэл гаргана.

5.5 Төв нь эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан тушаал, шийдвэрийн дагуу эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн салбар хороо, Эмийн эмчилгээг зохицуулах хороо, бусад шаардлагатай хороо, зөвлөлийг байгуулан ажиллуулна.

5.6 Төвийн Захирлын эрх, үүрэг:

5.6.1. Төвийг удирдлага, зохион байгуулалтаар хангах, төвийг бүрэн хэмжээгээр төлөөлөх, үйл ажиллагааны үр дүнг хариуцах;

5.6.2. Төвийн захирал жил бүр Төсвийн ерөнхийлөн захирагчаар тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлуулах, биелэлтийг хангах, хагас, бүтэн жилээр тайлагнах, ил тод мэдээлэх;

5.6.3. Эрүүл мэндийн даатгалын сангаас оношийн хамааралтай бүлгийн дагуу гүйцэтгэлээр хийгдэх санхүүжилтийг оновчтой төлөвлөх, зориулалтын дагуу зарцуулах, зарцуулалтыг хянах, ил тод байдлыг хангах;

5.6.4. Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн эрх зүйн орчин болон хэтийн төлөвлөлттэй уялдуулан төвийн зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээний цар хүрээ, тоо хэмжээг хүн амын хэрэгцээ шаардлагад үндэслэн төлөвлөх, ажилчдын тоо, цалин хөлсийг тогтоох;

5.6.5. Төвийн алба, тасаг, нэгжүүдийн үйл ажиллагааны чиглэл, чиг үүргийг тодорхойлох, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг батлах, хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангах, хяналт тавих;

5.6.6. Ажилтныг мэдлэг, боловсрол, ур чадварыг дээшлүүлэх, тасралтгүй сургалтад хамруулах, цалин хөлс, нийгмийн баталгааны асуудлаар гаргасан санал, хүсэлтийг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэх;

5.6.7. Байгууллагын ажилтнуудыг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу томилох, чөлөөлөх;

5.6.8. Ажилтнуудын албан тушаалын тодорхойлолт батлах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, дүгнэх, урамшуулах, сахилгын шийтгэл ноогдуулах, гэрээг



цуцлах;

5.6.9. Төвийн үйл ажиллагааг сайжруулах санал, арга хэмжээний үр ашгийг тооцож, ашигтай хувилбарыг хэрэгжүүлэх, дэмжлэг үзүүлэх;

5.6.10. Удирдах ажилтны ёс зүйг чанд сахиж, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид ажиллах;

### **Зургаа . Гадаад, дотоод хамтын ажиллагаа**

6.1 Төвийн захирлын гадаад улсад туршлага судлах, мэргэжлийн сургалтад суралцах, хурал, семинарт оролцох албан томилолтыг Эрүүл мэндийн сайдын тушаалаар шийдвэрлэнэ.

6.2 Төв нь төрийн захиргааны төв байгууллагын удирдлага, газрын дарга нартай шууд харилцаж, эрүүл мэндийн талаарх төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх ажлыг зохион байгуулахдаа чиглэл, үүрэг зөвлөмж авч үйл ажиллагаагаа уялдуулан ажиллана.

6.3 Төв нь өөрийн эрхлэх асуудлаар бусад эрүүл мэндийн байгууллага, төрийн ба төрийн бус байгууллага, иргэдтэй холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

### **Долоо. Дэд захирлын чиг үүрэг**

Төвийн дэд захирал нь нийт алба, тасгуудыг нэгдсэн удирдлага зохион байгуулалтаар хангаж дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

7.1. Настны эрүүл мэндийн тусламжийн чиглэлээр үзүүлэх тусгай мэргэшлийн тусламж, үйлчилгээ, холбогдох албадын үйл ажиллагааг уялдуулан нэгдсэн удирдлага, зохион байгуулалтаар хангаж, үйл ажиллагааны үр дүнг хариуцан ажиллах;

7.2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чиглэлээр стандарт, дүрэм, журам, удирдамж, заавар, аргачлал боловсруулан хэрэгжүүлэх, хяналт тавих;

7.3. Тусламж, үйлчилгээтэй холбоотой үндсэн үзүүлэлтүүдэд дүн шинжилгээ хийж сайжруулах санал, шийдвэрийн төслийг төвийн Захирал, Удирдлагын зөвлөлд танилцуулан шийдвэрлэж ажиллах;

7.4. Хөдөлмөрийн гэрээ, албан тушаалын тодорхойлолт хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргийг биелүүлэн ажиллана;

### **Найм. Албадын ерөнхий чиг үүрэг**

8.1. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлын алба

8.1.1 Төвөөс настанд үзүүлж буй эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд мөрдөх стандарт, удирдамжийн хэрэгжилтийг хангах, тусламж үйлчилгээний чанар, аюулгүй байдал, эрсдэл, үйлчлүүлэгчид учирч болох эрсдэлд хяналт үнэлгээ хийх, дэмжин туслах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх эмнэлгийн мэргэжилтэн, ажилтнуудын ажлын чанарт үнэлгээ, дүгнэлт, гаргах, чанарыг сайжруулах үйл ажиллагааг зохион байгуулах;

8.1.2 Үйлчлүүлэгчид болон ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа авах, төвийн хэмжээнд учирч болох эрсдэлийн үнэлгээ хийж, тодорхойлсон эрсдэлийг арилгах



арга хэмжээ авах;

8.1.3 Магадлан итгэмжлэлийн шалгуурыг хангаж ажиллах, чанар сайжруулах чиглэлээр ажилтнуудад сургалт, харилцан туршлага солилцох ажлыг зохион байгуулах, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарын шалгуур үзүүлэлтэд дүн шинжилгээ хийх, тухайн байгууллагад мөрдөх дүрэм, журам зааврын хяналтын хуудсыг хуульд нийцүүлэн боловсруулан мөрдүүлж хэрэгжилтийг хангах;

8.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээний алба

8.2.1 Настанд нотолгоонд тулгуурласан эрүүл мэндийн тусламж үйлчилгээг үзүүлэх, тусламж үйлчилгээнд мөрдөгдөх стандарт, удирдамжийг боловсруулж хэрэгжилтийг хангах;

8.2.2 Настны эрүүл мэндийн цогц үнэлгээг хийж, хэрэгцээнд тулгуурласан тусламж үйлчилгээний төлөвлөгөө боловсруулан, настны чадвар алдалтыг тодорхойлох, олон нийтийн оролцоонд түшиглэн чадвар, чадамжийн алдагдлыг бууруулах;

8.2.3 Сэргээн засах, насжилтаас үүдэлтэй өвчлөлийг оношлох, эмчлэх, эрт илрүүлэх арга хэмжээг тасралтгүй явуулах, гэрээр настанд үзүүлэх олон мэргэжлийн багийн тусламж үйлчилгээг өргөжүүлэх, анхан болон лавлагаа шатлалын эрүүл мэндийн байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, тусламж үйлчилгээний чанарыг тасралтгүй сайжруулахад эмч мэргэжилтнүүдийн оролцоог нэмэгдүүлэх;

8.3 Сургалт, эрдэм шинжилгээ, хамтын ажиллагааны алба

8.3.1 Настны чиглэлээр хэрэгжүүлж буй үндэсний хөтөлбөр, стратегийн хэрэгжилтэнд манлайлан оролцож зохион байгуулах;

8.3.2 Геронтологи, гериатрийн чиглэлээр судалгаа шинжилгээний ажил эрхлэх, судалгааны дүн, зөвлөмж боловсруулах, судалгааны чиглэлээр олон улсад нэвтэрч буй анагаах ухааны ололт амжилтын мэдээний сан бүрдүүлэх, нэвтрүүлэх, санал, зөвлөмж боловсруулах, нийгмийн эрүүл мэндийн сургалт, ухуулга нөлөөлөлийн ажлыг зохион байгуулах;

8.3.3 Төрийн болон төрийн бус байгууллагуудтай хамтран ажиллах, эмнэлгийн мэргэжилтнүүдийн ажлын байран дахь болон давтан, мэргэшүүлэх сургалтыг /багц цагийн/ зохион байгуулах, эмнэлгийн мэргэжилтэн бэлтгэж буй сургалтын байгууллагуудтай хамтран ажиллах;

8.3.4 Настанд чиглэсэн үйл ажиллагаа явуулах чиг үүрэг бүхий байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

8.3.5 Байгууллагын хөгжил дэвшил, эмчилгээ оношлогооны дэвшилтэт арга технологийн чиглэлээр гадаад харилцааг өргөжүүлэн олон улсын байгууллагатай хамтран ажиллах төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан ажиллах, харилцан туршлага солилцох үйл ажиллагааг зохион байгуулах, олон улсын эрдэм шинжилгээний хурал, сургалт, семинарт оролцох, өөрийн оронд зохион байгуулах, түүнд холбогдох хүмүүсийг оролцуулах;

8.3.6 Үндэсний хэмжээнд настны чиглэлээрх статистик мэдээ мэдээллийг цуглуулах, бүртгэх, мэдээлэх, дамжуулах, тайлагнах, мэдээний сан үүсгэн мэдээлэл солилцох үйл ажиллагааг хариуцах;

8.4 Стратеги төлөвлөлтийн алба

8.4.1 Төвийн алсын хараа, хэтийн зорилгыг үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй



уялдуулан тодорхойлж, түүнийг хэрэгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөг салбарын хэмжээнд дэвшүүлсэн бодлого шийдвэртэй нийцүүлэн боловсруулах, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийг бодитой тодорхойлох;

8.4.2 Төвийн хэмжээнд жил бүр болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулах төвийн үйл ажиллагааны үр дүн болон үйл ажиллагааны нэгжийн өртөг зардлыг тооцох;

8.4.3 Төсвийн үр ашгийг сайжруулах арга хэмжээг авах, байгууллагын дотоод журам, эрсдэлийн үеийн журам, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, тайлагнах, тулгамдсан асуудлаар төвийн удирдлагыг мэдээлэлээр хангах;

8.4.4 Настны чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагуудыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, төвийн хүний нөөцийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, ажилтнуудын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулах, төвийн эмч мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх давтан сургах, ажилтны нийгмийн баталгааг хангах болон цалин урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх;

8.4.5 Төвийн шинэ цогцолбор барилга, эд хөрөнгө, автомашин, эмнэлгийн тоног төхөөрөмж мэдээлэл, холбооны хэрэгслийн хэвийн үйл ажиллагааг хангах, засвар үйлчилгээг хийх, засвар үйлчилгээний холбогдолтой мэдээллийн сан үүсгэх, удирдлагыг шаардлагатай мэдээллээр хангах, гадаад болон дотоод орчны тохижилт, цэвэрлэгээ үйлчилгээг хийх;

8.4.6 Эмнэлгийн багаж хэрэгсэл, зөөлөн эдлэлийн ариутгал, халдваргүйтгэлийн үйл ажиллагааг гүйцэтгэх, төвийн харуул хамгаалалт аюулгүй байдлыг хангах, тушаал шийдвэр, эрх зүйн актын төсөл боловсруулж биелэлтийг хянах;

8.4.7 Байгууллагын нягтлан бодох бүртгэл санхүүгийн тайлан, Монгол улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, бусад холбогдох эрх зүйн актуудын заалтад нийцсэн харилцагч, хэрэглэгчийн шийдвэр гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээлэлээр хангах байдлаар зохион байгуулах, санхүүгийн мэдээллийг цуглуулах, тайлагнах, эд хөрөнгийн бүртгэл, хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

## 8.5. Санхүү бүртгэлийн алба

8.5.1 Нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланг Монгол Улсад мөрдөгдөж байгаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, шийдвэрийг хэрэгжүүлэх, шийдвэр гаргахад ач холбогдолтой, үнэн зөв мэдээллээр удирдлагыг хангах;

8.5.2 Байгууллагын санхүү бүртгэлийн мэдээллийг цуглуулах, бүртгэх, тайлагнах, нэгтгэн дүгнэх, хяналт үнэлгээний шийдвэрийг хэрэгжүүлэх тодруулга бэлтгэх ажлыг зохион байгуулах, үндсэн болон бусад хөрөнгийн бүртгэл, хяналт, ашиглалт хамгаалалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх;

## 8.6 Хяналт, шинжилгээ, дотоод аудитын алба

8.6.1 Дотоод хяналтын алба/ажилтан нь байгууллагын стратеги төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих, шаардлагатай тохиолдолд байгууллагын тодорхой чиг үүрэгт үнэлгээ хийх;

8.6.2 Хууль тогтоомжийн хэрэгжилтэнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, байгууллагын үйл ажиллагааг сайжруулах зөвлөмж гаргах, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хөндлөнгийн байгууллагаар хийлгэх



үнэлгээг зохион байгуулах, хууль эрх зүйн зөвлөгөө өгөх, тушаал, гэрээ хянах;

### **Ес. Төвийн санхүүжилт**

Төвийн санхүүжилт нь дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- 9.1 Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон салбарын бодлогын хэрэгжилтийг хангахад зориулан олгож буй улсын төсвийн санхүүжилт;
- 9.2 Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлсний төлөө эрүүл мэндийн даатгалын сангаас нэхэмжилж авах орлого;
- 9.3 Үндсэн (хууль тогтоомжоор зөвшөөрсөн төлбөртэй тусламж, үйлчилгээний орлого), туслах (хууль тогтоомжид нийцүүлэн олсон бусад орлого гэх мэт) үйл ажиллагааны орлого;
- 9.4 Төсвийн тухай хуульд заасан журмын дагуу Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, хувь хүний хандив, тусламж;
- 9.5 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт;
- 9.6 Төсөл, хөтөлбөрийн санхүүжилт;
- 9.7 Хууль тогтоомжид заасан бусад эх үүсвэр;

### **Арав. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах**

- 10.1. Төвийн захирлын саналыг үндэслэн Эрүүл мэндийн сайдын тушаалаар дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулна.

---o0o---



12 Эрүүл мэндийн сайдын 2022 оны  
... дугаар сарын 15 -ны өдрийн 1/608 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт



### ГЕРОНТОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН БҮТЭЦ

